



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 707

Улаанбаатар хот

### Г Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус үндэслэн “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2023 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 59,041,647.28 (тавин есөн сая дөчин нэгэн мянга зургаан зуун дөчин долоон төгрөг хорин найман мөнгө) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2023 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн захирал (Д.Бямбасүрэн)-д Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

3.“Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн захирал (Д.Бямбасүрэн)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

3.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

3.2.“Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, биетээр байхгүй, 8 нэрийн, 25,524,920.0 (хорин таван сая таван зуун хорин дөрвөн мянга есөн зуун хорь) төгрөгийн балансын үнэтэй, 20,248,636.0 (хорин сая хоёр зуун дөчин найман мянга зургаан зуун гучин зургаа) төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 5,276,284.0 (таван сая хоёр зуун далан зургаан мянга хоёр зуун наян дөрөв) төгрөгийн үлдэгдэл үнэ бүхий хөрөнгийг Нягтлан бодох бодлогын олон улсын стандартад заасны дагуу хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн шинж байдлаар нь ангилан, хөдлөх хөрөнгийг данснаас хасуулах, үл хөдлөх хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.4, 31.5 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллах;

3.3.Сургалт үйлдвэрлэлийн төвийн цайны газрын зориулалтаар, зөвшөөрөлгүй, гэрээгүй ашиглаулж байгаа байр талбайн хэмжилтийг баталгаажуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49,50,51 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.4. Сургалт үйлдвэрлэлийн төвийн цайны газрын байр талбай түрээслүүлснээс олсон орлого 920,000.0 (есөн зуун хорин мянга) төгрөгийг, хурлын танхим түрээслүүлснээс олсон орлого 3,875,000.0 (гурван сая найман зуун далан таван мянга) төгрөгийн орлогоос 40 хувь болох 1,550,000.0 (нэг сая таван зуун тавин мянга) төгрөгийг, 2023 оноос өмнөх төлбөрийн үлдэгдэл 2,103,272.73 (хоёр сая нэг зуун гурван мянга хоёр зуун далан хоёр төгрөг, далан гурван мөнгө) төгрөгийг төрийн сангийн 1009 0000 0703 тоот дансанд, 2024 оны 12 дугаар сард багтаан нөхөн төвлөрүүлэх;

3.5. “Эрчим хүчний хөгжлийн төв” (хуучнаар) төрийн өмчит үйлдвэрийн газрын нэр дээр бүртгэлтэй, 3 нэгж талбарын, 2,871,584,000.0 (хоёр тэрбум найман зуун далан нэгэн сая таван зуун наян дөрөв) төгрөгийн үнэлгээ бүхий, 27,151 (хорин долоон мянга нэг зуун тавин нэг) м<sup>2</sup> газрын эзэмших/ашиглах эрхийг шилжүүлэн авах ажлыг зохион байгуулах;

3.6. Эрчим хүчний газар, “Эрчим хүчний хөгжлийн төв” (хуучнаар) төрийн өмчит үйлдвэрийн газрын нэр дээр бүртгэлтэй, эзэмших/ашиглах эрхийн зөрчилтэй, 2 нэгж талбарын, 511,443,100.0 (таван зуун арван нэгэн сая дөрвөн зуун дөчин гурван мянга нэг зуу) төгрөгийн үнэлгээ бүхий, 5,342.0 (таван мянга гурван зуун дөчин хоёр) м<sup>2</sup> талбай бүхий, орон сууцны зориулалтаар ашиглуулсан газар, газрын төлбөрийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад санал боловсруулан хүргүүлэх, холбогдох арга хэмжээг авч ажиллах;

3.7. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” (хуучнаар) төрийн өмчит үйлдвэрийн газрын нэр дээр бүртгэлтэй, 1 нэгж талбарын, ажилчдын орон сууцны зориулалттай, үнэлээгүй, 4,997.0 (дөрвөн мянга есөн зуун ерэн долоо) м<sup>2</sup> талбай бүхий, эзэмших/ашиглах эрхийн газрыг компанийн нэр дээр шилжүүлэн авах, үнэлэх ажлыг зохион байгуулах;

3.8. Газрын нэгдсэн мэдээллийн санд “Эрчим хүчний хөгжлийн төв” (хуучнаар) төрийн өмчит үйлдвэрийн газрын нэр дээр тус газраас захиалагчийн хяналт хийж байсан, 13 нэгж талбарын, 8,919,698.0 (найман сая есөн зуун арван есөн мянга зургаан зуун ерэн найм) м<sup>2</sup> талбай бүхий газар эзэмших/ашиглах эрх бүртгэгдсэн байгааг залруулж, мэдээллийн сангийн бүртгэлээс хасуулах ажлыг зохион байгуулах;

3.9. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 318 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар шилжин ирсэн 33,000,000.0 (гучин гурван сая) м<sup>2</sup> талбай бүхий газрын эзэмших/ашиглах эрхтэй холбоотой үүссэн шүүхийн маргааныг эцэслэн шийдвэрлэх, газар дээр баригдсан төслийн хөрөнгийн эзэмшигч, ашиглагчийг тогтоосны үндсэн дээр чанар, ашиглалтын байдлыг үнэлэх, төрийн өмчид хүлээн авах эсэх асуудлыг судлан шийдвэрлэх;

3.10. Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” (хуучнаар) төрийн өмчит үйлдвэрийн газрын нэр дээр бүртгэлтэй, УНТ сер, 16-48 улсын дугаартай автомашиныг компанийн нэр дээр шилжүүлэн авах.

4. Тогтоолын биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн  
707 дугаар тогтоолын хавсралт

“Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит  
хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хийсэн шалгалтаар  
илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний  
жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /төгрөг/	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Зориулалтын бусаар зарцуулсан зардлын талаар	1,080,000.00	Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5, “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах хориглоно
2	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, тооллоготой холбоотой	25,524,920.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах;
3	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээс, холбоотой	1,918,000.00	ТӨБЗГ-ын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай” 49 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах;
4	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээс, холбоотой	2,103,272.73	ТӨБЗГ-ын 2020-02-18-ны өдрийн “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 50 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах;
5	Компанийн нэр дээр шилжүүлээгүй газар эзэмших/ашиглах эрх	4 нэгж талбар, 32,148 м <sup>2</sup>	Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын холбогдох заалтыг мөрдөн ажиллах;
6	Орон сууцны зориулалтаар ашиглуулсан эрхийн зөрчилтэй газар эзэмших/ашиглах эрх	2 нэгж талбар, 5,342 м <sup>2</sup>	Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын холбогдох заалтыг мөрдөн ажиллах;
7	Газрын мэдээллийнсанд бүртгэгдсэн газар эзэмших/ ашиглах эрх	13 нэгж талбар, 8,919,698 м <sup>2</sup>	Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын холбогдох заалтыг мөрдөн ажиллах;
8	Компанийн нэр дээр шилжүүлээгүй тээврийн хэрэгслэл	28,415,454.55	Компанийн нэр дээр шилжүүлэх асуудлыг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т тавьж шийдвэрлүүлэх;
<b>НИЙТ ДҮН</b>		<b>59,041,647.28</b>	(тавин есөн сая дөчин нэгэн мянга зургаан зуун дөчин долоон төгрөг хорин найман мөнгө)